

ГАРЧИГ

НЭГ.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
1.1.Төслийн ерөнхий мэдээлэл	2
1.2.Төслийн байршил, тойм зураг	2
1.3.Төслийн зорилго	3
1.4.Төслийн хүчин чадал	3
1.5.Төслийн дэд бүтэц.....	3
ХОЁР.ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	4
ГУРАВ.ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	6
ДӨРӨВ.БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	7
ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	9
ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	10
ДОЛОО.ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	11
НАЙМ.ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	11
ЕС. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	13
АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	14
АРВАН НЭГ. 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	14
АРВАН ХОЁР. 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	15

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Үйлдвэрийн усны нийт хэрэглээ /жилээр/.....	3
Хүснэгт 2. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний зөвлөмж	6
Хүснэгт 3. 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	8

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.Төслийн талбайн байрзүйн зураг.....	2
---	---


НЭГ.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1.Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн нэр:	Электроникийн хаягдал, хаягдал зэс боловсруулах үйлдвэр
Төсөл хэрэгжүүлэгч:	“Нью метод” ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	9011594079
Регистрийн дугаар	6079415
Хаяг:	Улаанбаатар хот,Баянзүрх дүүрэг, 27-р хороо, Дунд дарь эх 16, 1263 тоот
Холбоо барих утасны дугаар:	99352406
Имэйл хаяг:	

1.2.Төслийн байршил, тойм зураг

Үйлдвэр нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт “Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк”-д гэрээний дагуу эзэмшиж буй 1 га талбайд байрлаж байна.



Зураг 1.Төслийн талбайн байрзүйн зураг

1.3.Төслийн зорилго

1. Хаягдал зэс, зэс агуулсан хаягдлыг иж бүрэн хэмжээнд боловсруулах дэвшилтэт технологийг үйлдвэрт нэвтрүүлэх, аж үйлдвэржилтийг нэмэгдүүлэх замаар дотоодын эдийн засагт дэмжлэг үзүүлэх;
2. Электроникийн хаягдал, хаягдал кабель утас зэрэг зэс агуулсан хаягдлыг боловсруулалтад оруулж түүнээс өнгөт, үнэт металлуудыг ялган авах замаар хог хаягдлыг дахин боловсруулах, хог хаягдлын хэмжээг багасгах;
3. Хог хаягдлаас хүнд металлуудыг ялган авах замаар хөрс, орчны бохирдлыг бууруулах;

1.4.Төслийн хүчин чадал

Жилд 500 тн электроникийн хаягдал, 300 тн хаягдал зэс боловсруулж 300 тн катодын цэвэр зэс, 10 тн цагаан тугалга, 2.7 кг алт, 27 кг мөнгө үйлдвэрлэнэ. Хуванцар хэсгийг дахин боловсруулж тус бүр 1.5 кг жин бүхий 120000 ширхэг хуванцар эдлэл жилд үйлдвэрлэнэ. Электроникийн хаягдалыг дагалдаж цуглах 25тн лити болон никель ионы батарейг дахин боловсруулж хоргүйжүүлэх, лити болон бусад металлыг ялган авах үйл ажиллагаа явуулна.

1.5.Төслийн дэд бүтэц

Цахилгаан хангамж: Налайх дүүргийн нэгдсэн хангамжаас 250 КВА

Дулаан хангамжийн шийдэл: Сайжруулсан түлшээр ажиллах уурын зуухтай

Усан хангамж: Гүний худаг /2023 онд усны газрын дүгнэлт, Налайхын үйлдвэр технологийн паркттай хийсэн ус ашиглах гэрээний дагуу 2л/сек ундрагатай 150м гүн худгийн үйлдвэрийн хашаан дотор гаргасан/. Үйлдвэрийн хэрэгцээнд усыг маш багаар ашигладаг.

Хүснэгт 1. Үйлдвэрийн усны нийт хэрэглээ /жилээр/

№	Хэрэглээний төрөл	Тооцоо	Нийлбэр дүн (м³)
1	Ахуйн хэрэглээ	150л/хүн×10хүн×300өдөр/1000	450,0
2	Үйлдвэрийн хэрэглээ /ууршуулалтад/	0.5м³/т×300т	150,0
3	Төлөвлөөгүй зарцуулалт	10%	60
	Нийт		660

**ХОЁР.ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН
ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ**

№	Үзүүлэлтүүд	Утга
1	Уур амьсгал	Улаанбаатар хот орчмын уур амьсгалын үзүүлэлтүүд нь хүйтэн өвөлтэй, сэрүүвтэр зунтай эх газрын эрс тэрс уур амьсгалтай бүс нутагт хамаарна. Жилд дунджаар 2800 цаг нартай байдаг бол 12-14 өдөр наргүй бүрхэг өдөр тохиож байдаг байна. Жилийн дундаж агаарын температур төв хэсэгтээ -4.0°C-ээс хүйтэн байх боловч газрын гадаргаас ихээхэн шалтгаалж өөр байна. Тухайлбал, Тэрэлж голын сав, Туул голын явцуу хөндийд -4-4.2°C ба үүнээс ч хүйтэн байдаг. 1-р сарын агаарын дундаж температур -21,5°C, голын хөндий дагуу 21.0-23.0°C, 7-р сарын агаарын дундаж температур уул өөдөө 39,0°C, голын хөндий болон өвөр эзвэр газар 38.0°C дулаан байна. Ургамал ургах идэвхтэй температур буюу 5.0°C-ээс дулаан үе 126 хоног, 1294°C байхад зуны ашигтай температур буюу 10.0°C-ээс дулаан 72 хоногт 878°C хуримтлагддаг нь манай орны өндөр уулын бүс нутгийн өвөрмөц онцлог юм. Уулын байрлал хотгор гүдгэрийн онцлог байрлалаас хамаарч газрын гадаргын орчмын салхины горим ихээхэн өөр өөр байдаг байна. Салхины жилийн дундаж хурд 0,9-2.3м/сек, Салхины дундаж их хурд 5 сард 1.2-4.0м/сек хамгийн намуун үедээ 12-1 сард 0.7-1.4 м/сек дундажтай байна. Агаарын чийгшлийн горим нэлээд өвөрмөц, агаарын чийгшил нь халуун хүйтэнтэй урвуу хамааралтай байдаг. Жилд унах хур тунадасны нийлбэрийн олон жилийн дундаж 350 орчим мм байхаас 95-97 хувь нь дулааны улиралд унах ба олон жилийн нийлбэрийн дундаж нь 100-120 мм хүрнэ. Анхны цас 9 сарын эхээр орж хаврын сүүлчийн цас 5 сарын дундуур ажиглагдаж болно. Салхины хурд бусад нутгаас бага, жилийн дунджаар 0.9-1.5 м/с байх боловч голын хөндийгөөр 2.5-4.8 м/с хүртэл нэмэгддэг. Агаарын даралт дунджаар 843 гПа байх боловч голын хөндийгөөр 865 гПа (650 мм) хүртэл хэлбэлзэнэ.
2	Геологийн тогтоц	Улаанбаатар хотын геологийн тогтоц нь кембри, девон, карбоны эрин үед үүссэн тунамал, хувирмал чулуулаг, тэдгээрийг нэвтэлж газрын гүнд царцаж тогтсон юра, триасын настай боржин чулуулаг, эдгээр үндсэн чулуулгийг бүрхэж тархсан цэрдийн эринд үүссэн цайвар саарал өнгийн элсжин, зануужин, гуравдагчийн улаан, улаавтар шар өнгийн хайргатай элсэрхэг болон наанги шавар, шавранцар, элсний нимгэн үе, дөрөвдөгчийн үед үүссэн элс, хайрга, шавар, хайргажин зэрэг хурдас, чулуулгаас бүрддэг.
3	Агаарын чанар	Улаанбаатар хот нь хөл хөдөлгөөн ихтэй тул тус авто зам жилийн дөрвөн улиралд байнгын ачаалалтай байдаг бөгөөд автомашины хөдөлгөөнөөс ялгарах хорт хий цэгэн эх үүсвэртэй агаарын бохирдол үүснэ.Мөн автомашины хөдөлгөөн,үйлдвэрийн машин тоног, төхөөрөмжийн дуу чимээ,чичиргээ бага зэрэг үүснэ. Энэхүү нөлөөлөл нь хүн, амьтанд ихээр нөлөөлөхгүй ба нөлөөллийн үргэлжлэх хугацаа нь харьцангуй бага байна.
4	Хөрсөн бүрхэвч	Төслийн талбайд хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй, уулын хар хүрэн хөрс тархсан байна. Лабораторийн задлан шинжилгээний дүнгээс үзэхэд уг хөрс нь сул шүлтлэг урвалын орчинтой, карбонатгүй, ялзмагийн агууламжаар дунд зэрэг, цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй, хөдөлгөөнт фосфор болон калийн хангамжаар дунд зэрэг байна. Хөрсний үржил шимийн ерөнхий түвшин дундаж байна.

5	Ургамал	А.А.Юнатов (1946, 1950) ургамалжлын хэв шинжийн тархан байрших зүй тогтолд тулгуурлан Монгол орны ургамалжлыг анх бүсчилжээ. БНМАУ-ын ургамалжлын бүсчлэлээр Улаанбаатар хотын нутаг дэвсгэр нь хээрийн бүсэд хамаарч байна. Хээрийн бүсийн ургамалжил нь хуурайсаг үетэн зонхилсон өвслөг ургамал, сөөг, сөөглөг болон сөөгөнцөрлөг ургамлаас бүрддэг . Энэхүү бүсэд крыловын Хялгана, том Хялгана, дэрвээн Хазаарөвс, хиаглай Түнгэ болон бяцхан навчит Харганы хэвшлүүд түгээмэл тохиолдоно. Харин ургамал газарзүйн мужлалаар Улаанбаатар хот нь Евро-Азийн хээрийн муж, Дагуур Монголын хээрийн хошуу, Дундад Халхын хээрийн тойрог, Өнжүүлийн дүүрэгт хамаарч байна. Ургамалжлын зүйлийн хувьд 17 овгийн 30 төрлийн нийт 33 зүйл ургамал бүртгэгдсэн байдаг.
6	Гадаргын ус	Улаанбаатар хот нь Туул голын сав газрын II дэд хэсэгт байрладаг. Туул гол нь Хан Хэнтийн нурууны салбар Бага Хэнтий уулын ар, өврөөс эх авах Номин, Нэргүй голын бэлчрээс Туул нэрийг авч Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутагт Орхон голд цутгадаг. Голын ус хурах талбай нь 49'774.4 км² , голын нийт урт 717 км. Үүнээс 152 км нь Улаанбаатар хотоос дээш, 93 км нь Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт, 472 км нь нийслэл хотоос доош хэсэгт хамаарна. Туул голын сав газарт Монгол Улсын нийт хүн амын 46.3% нь амьдарч, дотоодын нийт бүтээгдэхүүний 60 гаруй хувийг үйлдвэрлэж байна.
7	Гүний ус	Туул голын сав газрын хэмжээнд 2018 оны байдлаар 572.3 мян.м3/хон ашиглах боломжит нөөц бүхий газрын доорх усны орд 22 байгаа бөгөөд эдгээрээс Улаанбаатар хотын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрт 7, цахилгаан станцуудын эх үүсвэрт 3, Төв аймгийн Хөшгийн хөндийд 1 орд буюу нийт 11 орд ашиглагдаж, үлдсэн 11 орд нь ашиглагдаагүй байна. Улаанбаатар хот байрлаж буй II дэд хэсэгт улсын хэмжээнд хамгийн их ус ашиглалт буюу газрын доорх усны ашиглах боломжит нөөцийн 44.7%-ийг ашигладаг байна . Улаанбаатар хотод Дээд, Төв, Гачуурт, Үйлдвэр, Мах, Нисэх, Яармаг гэсэн цэвэр ус хангамжийн эх үүсвэрүүдийн 7 цооног нь газрын доорх усны хяналт шинжилгээний нэгдсэн сүлжээнд холбогдон хотын хүн амыг унд, ахуйн цэвэр усаар хангаж байна. Эдгээр эх үүсвэрүүд нь Туул голын хажууд, сэвсгэр хурдсанд байдаг ба эдгээр нөөц нь нөхөн сэргээгддэг нөөцөд ордог байна. Төслийн хэрэгцээт усыг гүний худгаар хангана. /2023 онд усны газрын дүгнэлт, налайхын паркттай хийсэн ус ашиглах гэрээний дагуу 2л/сек ундрагатай 150м гүн худгийн үйлдвэрийн хашаан дотор гаргасан/
8	Амьтан	Төсөл хэрэгжих талбайн орчмын нутаг дэвсгэр нь Улаанбаатар хотын эдэлбэр нутаг дэвсгэр учир амьтны аймгийн хувьд аль хэдийн нөлөөлөлд өртөж зүйлийн баялагаар тун ядмаг болсон байна. Түүнчлэн тухайн орчны шувуудын зүйлийн баялагт тодорхой хэмжээний өөрчлөлт орж, суурин газрын хүнд ойриймсог (синонтроп) зүйлүүд илүүтэй үзэгдэх болсон байна. Иймээс, тус төслийн зүгээс амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл бага байна.

ГУРАВ.ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, аргачлалын дагуу хийж гүйцэтгэсэн.

Хүснэгт 2. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний зөвлөмж

№	Гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ
Агаар орчин		
1	Үйлдвэр орчмын хөрсний элэгдэл, автомашины яндангаас үүсэх утаа, тоосжилт зэрэг нь агаарын бохирдлыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх эх үүсвэр болно.	Төслийн хэрэгцээнд ашиглаж буй автомашины яндангаас үүсэх утаа, хорт хийг багасгах зорилгоор тэдгээрийн техникийн засвар үйлчилгээг тогтмол хийх, эвдрэл гэмтлийг даруй засаж байх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх; Үйлдвэрийн хэрэгцээнд ашиглагдах зам талбайг цардах, засаж янзлах;
Хөрс болон ургамлан бүрхэвч		
2	Тээврийн хэрэгслийн техникийн шатах тослох материал, хатуу хог хаягдлаар тодорхой хэмжээний газар бохирдож болзошгүй.	Төслийн үйл ажиллагааны явцад тос, тослох материалыг аль болох ил задгай хаяхгүй байх арга хэмжээг авч ажиллах; Хөрсөн бүрхэвчийн чанарын өөрчлөлт, элэгдэл эвдрэлийг тогтмол хянаж байх, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах; Үйлдвэр орчимд мод, бут тарих; Ажилчдын ахуйн хэрэглээнээс гарсан хатуу хог хаягдлыг цуглуулах бетонон суурьтай “Хогийн цэгийн байгууламж” байгуулах.
Болзошгүй аюул, осол		
3	Галын болзошгүй аюул осол гарах;	Үйлдвэрийн цахилгаан монтажийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих; Үйлдвэрт гал унтраах хор, хэрэгслүүдийг бэлтгэж тавих /гал унтраагуур, элс, шороо, хүрз, хөөс гэх мэт/
4	Химийн бодистой харьцаж буй ажилтнууд хувийн ариун цэвэр, эрүүл ахуйн дүрмийг мөрдөж ажиллаагүйгээс эрүүл мэндэд нөлөөлөх; Тээвэрлэлт, ачилт, буулгалтын үед санамсаргүй байдлаар асгарч нүд, арьсанд сөрөг нөлөөлөл үүсгэж болзошгүй.	Ажилчдын эрүүл мэндийн үзлэг Химийн бодистой харьцах үеийн зориулалтын хувцас /гутал, резинен бээлий, хамгаалалтын хошуувч/ Химийн бодисын эрсдэлийн үнэлгээнд заасны дагуу эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэх

ДӨРӨВ.БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Улаанбаатар хотын Налайх дүүргийн 3-р хорооны нутагт байрлаж буй “Нью метод” ХХК-ийн “Электроникийн хаягдал, хаягдал зэс боловсруулах үйлдвэр” төслийн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг БОАЖЯ-ны сайдын 2019 оны А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримтлан боловсруулсан болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны-хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгалийн нөөц баялгийг ашиглах явцад байгаль орчныг доройтохоос урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахтай холбогдсон арга хэмжээг тодорхойлон, шаардагдах хөрөнгө зардлыг тооцож, хариуцах этгээд, хэрэгжүүлэх хугацаа, баримтлах хууль, журам, аргачлал, стандартыг тодорхойлж тусгасан.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төсөл хэрэгжүүлэх явцад байгаль орчинд үүсч болзошгүй өөрчлөлтийг хянах, шинжлэх объект, байршил, баримтлах стандарт, арга аргачлал, хугацаа, хариуцах этгээд, хяналт шинжилгээний үр дүнг тайлагнах талаар тусгахаар хуульчлагдсаныг баримтлан боловсруулав.

“Нью метод” ХХК-ийн “Электроникийн хаягдал, хаягдал зэс боловсруулах үйлдвэр” төслөөс байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл дунд хэдий ч сөрөг нөлөөллийг багасгахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Байгаль орчны үнэлгээний тайлан болон төслийн талбайд хийсэн хээрийн судалгаа, шинжилгээний дүн зэргийг үндэслэн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний голлох зорилтуудыг дэвшүүлж байна.

Үүнд:

- Үйлдвэрлэлийн орчны ногоон байгууламжийн талбайг ихэсгэх
- Үйлдвэрийн болон оффисоос гарч буй хатуу хог хаягдлуудыг ангилан ялгах системийг нэвтрүүлж, хатуу хог хаягдлыг дахин боловсруулдаг компанид нийлүүлэх
- Аюултай хог хаягдлыг тухай бүр мэргэжлийн байгууллагад шилжүүлэх
- Үйлдвэрлэлийн үеийн агаарын бохирдлыг хянах, багасгах, ажилчдыг хамгаалах хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр тогтмол хамгаалах

- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлэх
- Үйл ажиллагааны явцад учирч болзошгүй эрсдэл аюулаас бүрэн сэргийлж ажиллах, холбоотой сургалтыг тогтмол зохион байгуулах

Хэдийгээр үйлдвэрийн үйл ажиллагаа нь байгальд үзүүлэх хүчтэй, том хэмжээний талбайг хамарсан нөлөөлөл үүсэхгүй боловч бичил экосистемд бага хэмжээний нөлөөлөл бүрэн арилгаж ажиллах нь зүйтэй юм. Үйлдвэрийн ажилчдын болгоомжгүй санамсаргүй үйл ажиллагаанаас үүдэлтэй томоохон хэмжээний аюул, осол гарч болзошгүй бөгөөд эрсдэлийн үнэлгээний хэсэгт заасны дагуу технологийн заавар, дүрэм, санамж зэргийг байнга даган мөрдөн ажиллах зайлшгүй шаардлагатай болно.

Байгаль орчны менежментийн 2026 оны төлөвлөгөөний нийт зардалд 6.215.0 мянган (зургаан сая хоёр зуун арван таван мянга) төгрөг төлөвлөлөө.

2026 оны БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг тухайн оны 12-р сарын 01-ний дотор Нийслэлийн Байгаль орчны газарт ирүүлж, орон нутгийн засаг захиргааны байгууллага, нутгийн оршин суугчдад танилцуулж, тэднээр хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулна.

Хүснэгт 3. 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

№	Үйл ажиллагааны төлөвлөгөө	Зардал /төгрөг/
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1600000
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	540000
3	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1000000
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	950000
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	525000
7	2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	1600000
8	2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	-
	2026 ОНЫ НИЙТ ДҮН	6.215.000

**“ЭЛЕКТРОНИКИЙН ХАЯГДАЛ, ХАЯГДАЛ ЗЭС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР”
ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нийт зардал,төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Уурын зуухнаас агаарт утаа, тоосонцор ялгарч бохирдуулах	Уурын зуухны янданд шүүлтүүр суурилуулах, тогтмол сольж хэвших	Уурын зуух	600000	X/01	- MNS4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага - MNS4990:2000 Ажлын байрны эрүүл ахуй ба хөдөлмөр хамгаалал. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага - MNS5885:2008 Агаар бохирдуулагч бодисуудын хүлээн зөвшөөрөгдсөн концентрац. Техникийн ерөнхий шаардлага - MNS5924:2015 Нүхэн жорлон. Угаадасны нүх Техникийн шаардлага
2	Хүхрийн хүчлийн уур үүсэж хүний эрүүл мэнд, ажлын байрны агаарын чанарт сөргөөр нөлөөлөх	Үйлдвэрийн үйл ажиллагаанаас хүхрийн хүчлийн уур үүсэхээс сэргийлж агаарын чанарын хяналтыг агаарын чанарын хяналт шинжилгээний хөтөлбөрт заасан зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх, тогтмол хяналт тавих	Үйлдвэрийн байр, дотоод орчин	ОХШХ-т тусгагдсан.	XI/15 болон IX/15	
3	Химийн бодистой шатах, гал авалцах эх үүсвэрийг ойр байлгаснаар гал түймэр гарах, тэсэрч дэлбэрснээр хортой хий ялгаран агаарын чанар, хүний эрүүл мэндэд нөлөөлөх	Химийн хортой болон аюултай бодисын хадгалалтын болон хадгалах хугацааны горимыг нарийн чанд баримтлах, ялангуяа тодорхой хугацааны дараа уурших, задрах гэх мэтээр бүтэц найрлага нь өөрчлөгддөг тогтвортой биш бодис болон савлагааны материал нь хязгаарлагдмал ашиглалтын хугацаатай химийн бодисыг агуулахад хадгалахад үйлдвэрлэгчээс зааж өгсөн хугацааг хянах,		-	Сар болгон	
4	Химийн бодистой харьцан ажиллах үед санамсаргүй асгах, алдах, ажлын байранд асгарснаас орчны агаарын чанарт нөлөөлөх.	Үйлдвэр, химийн бодисын агуулахын ажиллагсад бодистой ажиллах болон асгарсан бодисыг саармагжуулах, хурааж авах зэрэг ажиллагааны явцад хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэлгүй ажиллах зэрэг тохиолдолд бодист түлэгдэх, бодисын уураар амьсгалах, хордох зэрэг эрсдэл үүсэж болзошгүй тул хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг сайтар ханган ажиллах			Сар болгон	

**“ЭЛЕКТРОНИКИЙН ХАЯГДАЛ, ХАЯГДАЛ ЗЭС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР”
ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

5	Ажилтнууд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллаагүйгээс ажлын байранд химийн бодис алдагдах, хүний эрүүл мэндэд нөлөөлөх	Үйлдвэрт ажиллаж буй мэргэжилтэн нь хор аюулын лавлах мэдээлэлд заасан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллахаас гадна химийн бодис алдагдахаас урьдчилан сэргийлсэн бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх, асгарч алдагдсан тохиолдолд түүнийг саармагжуулах арга хэмжээг авах чадварыг эзэмшсэн байх, мэргэжлийн сургалтад хамрагдах	Бүх ажилчид	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан.	XI/01-ний өдрийн дотор
6	Хөрсөнд их хэмжээний химийн бодис алдагдсанаар ургамалжилт, хөрсний бичил биетэнд дам нөлөөлөл үзүүлэх	Үйлдвэрийн ажлын байр нь тухайн бодисын хор аюулын лавлах мэдээлэлд заасан шингээгч материалаар (зориулалтын шингээгч, хуурай элс, тогтворжуулагч, үртэс гэх мэт) хангагдсан байна. Химийн бодис асгарах, алдагдах үед ашиглах нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хоосон сав, бортого, бортого онгойлгогч, наалддаг шошго, металл юүлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тэмдэг болон тууз зэрэг багаж хэрэгслээр хангагдсан байх	Үйлдвэрийн байр, дотоод орчин	1000000	Сар бүр тогтмол шинэчлэх
7	Нүхэн жорлонгийн сөрөг нөлөөллийг бууруулах	Үйлдвэрийн байранд эко жорлон суурилуулах	Үйлдвэрийн байр	-	2026 оны 1-р улиралд
8	Газрын гүний усыг хяналтгүйгээр их хэмжээгээр ашигласнаас усны нөөцөд нөлөөлөх	Гүний худгийг тоолууржуулах, тоолуурын заалтыг үндэслэн төлбөр төлж байх шаардлагатай.	Гүний худаг	-	Сарын 25-ны өдрийн дотор
Нийт				1600000	

ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд нэгдэж 2026 онд 50 ширхэг хайлаас тарьж арчилан ургуулах ба БОМТ-ний төлөвлөгөөнд зардлыг тусгав. Хайлаас нь бүх байгалийн бүс бүслүүрт ургадаг цорын ганц мод юм.

**“ЭЛЕКТРОНИКИЙН ХАЯГДАЛ, ХАЯГДАЛ ЗЭС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР”
ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Түүнээс гадна хайлаас нь улиас зэрэг бусад том хэмжээний навчит модноос ялгарах гол онцлог нь таналт тайралт сайн даадаг тул эгнүүлэн суулгаад жил бүр засаж тайрч, ногоон хашлага болгож ургуулах боломжтой байдаг. Хайлаасны суулгацыг ургамлан хашлага, цөлжилттэй тэмцэх зэрэгт их хэмжээгээр хэрэглэгддэг.

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Үйлдвэрийн хашааны дагуу мод,бут тарих	Хайлаас, тарьж ургуулах	Хашааны дагуу	ш	50	2500	125000	2026 оны II-III улиралд	MNS5914-2008. Байгаль орчин.Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт MNS 5918:2008.Байгаль орчин.Эвдэгдсэн газрын ургамлыг нөхөн сэргээх. Техникийн ерөнхий шаардлага
2	Хар шороо бэлдэх	Хэлбэржүүлэх, услах , бордох		машин	1	340000	340000		
3	Бордох, /гумины бордоо/			уут	10	7500	75000		
4	Услах, арчлах			-	-	-			
	Нийт					350000	540000		

ДОЛОО.ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллах шаардлагатай. “Нью метод” ХХК-ийн төслийн байршил, онцлогоос хамаараад түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний ажил хийгдэхгүй болно. Тус төслийн талбай орчимд түүх соёлын дурсгалд тооцож болохуйц газар болон археологийн болон палентлогийн олдвор одоогоор тохиолдоогүй.

НАЙМ.ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**“ЭЛЕКТРОНИКИЙН ХАЯГДАЛ, ХАЯГДАЛ ЗЭС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР”
ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Үйлдвэр, химийн бодисын агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдлоос үүдэн аюул, осол гарах	Үйлдвэр, химийн бодисын агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдлоос үүдэн аюул, осол гарахаас байнга урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, агуулахын бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавих;	Үйлдвэрийн гадна болон дотор орчин	Урьдчилан тооцох боломжгүй.	2026 оны туршид	-
2	Аянга цахилгаан, гэнэтийн хүчтэй цахилгаан гүйдлийн нөлөөгөөр орчинд тархах, алдагдах	Үйлдвэр, ажлын байр нь галд тэсвэржилтийн зэргийг хангахуйц материал, хийцтэй, болзошгүй ослын үед хөрсөнд болон гадагш бодис алдагдахааргүй шал (цементэн болон плитан), бат бэх хамгаалалт бүхий цонх, хаалгатай байхаар засаж тохижуулах		-		
3	Болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх	“Аюул, ослын үед ажиллах төлөвлөгөө” боловсруулж, тухайн орон нутгийн Онцгой байдлын газраар батлуулах, хэрэгжүүлэх		500000	Х/01-ний өдрийн дотор	
4		Анхааруулах тэмдэг тэмдэглэгээ, хаягжуулалт, мэдээллийн самбарыг байрлуулах				
5	Анхаарал болгоомжгүй байдлаас үүсэх осол гэмтлээс сэргийлэх	Химийн бодистой харьцаж ажилладаг ажиллагсдыг үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг хянах, эрсдэл үүссэн тохиолдолд хариу арга хэмжээ авах мэдлэг, дадлыг эзэмшүүлэх сургалтад заавал хамруулсан байх	Бүх ажилчид	500000	Х/01-ний өдрийн дотор	
6		Үйлдвэрийн байр, талбайг бүрэн камержуулах, гэрэлтүүлэг тавих,	Үйлдвэрийн гадна болон дотор орчин	-		
	Нийт			1000000		

**“ЭЛЕКТРОНИКИЙН ХАЯГДАЛ, ХАЯГДАЛ ЗЭС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР”
ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

ЕС. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Тоо хэмжээ	Нийт зардал,төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн	Энгийн хог хаягдлын бүртгэл хөтлөх	Үйлдвэрийн үйл ажиллагаа	Үүссэн хэмжээгээр	100000	Сар бүрийн 25-ны өдрийн дотор	Хог хаягдлын тухай хуулийн 10.2
		Энгийн хог хаягдлыг дахин ашиглах, зайлуулах ажлыг үргэлжлүүлэх					
		Энгийн хог хаягдлыг дахин боловсруулах гэрээт байгууллагад нийлүүлсэн тохиолдолд тээврийн зардлыг төлөх		12 сар	250000		
		Энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамж төлөх					
2	Аюултай	Аюултай хог хаягдлын бүртгэл хөтлөх , хуулийн хугацаанд тайлагнах		Үүссэн хэмжээгээр	200000	Гэрээний дагуу	Хог хаягдлын тухай хуулийн 29.1 дэх хэсэг
		Аюултай хог хаягдлыг эрх бүхий байгууллагад гэрээний дагуу шилжүүлэх					Хог хаягдлын тухай хууль
		Аюултай хог хаягдлын үйлчилгээний төлбөрийг төлөх					
3	Орчны бохирдол үүсэхээс урьдчилан сэргийлж хог хаягдал түр хадгалах цэгийг тохижуулах				1	400000	VIII/15
4	Хог хаягдал хариуцсан ажилтантай болох			-	-	III/01	Хог хаягдлын тухай хуулийн 10.2.17 ба 23.7
5	Хог хаягдлын менежмент,сэдэвт сургалт, мэдээллийг нийт ажилтнуудад өгөх		Нийт ажилтнууд	-		X/01-ний өдрийн дотор	Хог хаягдлын тухай хууль 10.2.16 ба 26.1.3
6	Нийт				950000		

**“ЭЛЕКТРОНИКИЙН ХАЯГДАЛ, ХАЯГДАЛ ЗЭС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР”
ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
1	Хөрсний эрүүл ахуй	Хог хаягдлын цэг орчмоос	V/15 болон IX/15	Жилд 2 удаа	25000	50000	“Грийн лаб”-ийн үнээр	MNS5850:2019
	Хөрсний хими физик шинж чанар				25000	50000		
	Хөрсний хүнд металл				25000	50000		
2	Агаарын чанарын үзүүлэлт	Үйлдвэрийн гадна агаар	XI/15 болон IX/15	Жилд 2 удаа	37500	75000	Байгаль орчин, хэмжилзүйн төв лабораторийн үнээр	MNS4585:2025 MNS5885:2008
3	Ундны усан дахь эмгэг төрүүлэгч бактерийн тоо	Гүний худгаас	V/15 болон IX/15	Жилд 2 удаа	50000	100000	“Грийн лаб”-ийн үнээр	MNS 900:2018
	Ундны усны бүрэн шинжилгээ				50000	100000		
	Ундны усан дахь хүнд металлын агууламж				50000	100000		
Нийт					-	525000		

**АРВАН НЭГ. 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2026 он				
			Сар ...	Сар ...	Сар ...		
1	2026 оны байгаль орчны менежментийн биелэлтийн тайланг боловсруулж дүгнүүлэх	-	Жил бүрийн 12-р сарын 01-ний дотор				
2	2027 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах		XII/01				

**“ЭЛЕКТРОНИКИЙН ХАЯГДАЛ, ХАЯГДАЛ ЗЭС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР”
ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

3	Хог хаягдлын гэрээг холбогдох хот тохижилтын газартай гэрээ байгуулах				“Нью метод” ХХК-ийн удирдлага, холбогдох менежер		
4	Мэргэжлийн байгууллагатай хамтран аюултай хог хаягдлыг тээвэрлэн, зайлуулах гэрээг хийж, гүйцэтгэлийг хангах.						
5	Ус, газар, хог хаягдал, агаарын бохирдлын хураамжийг гэрээний дагуу төлөвлөгөөт хугацаанд барагдуулах.						
6	Галын аюулаас урьдчилан сэргийлэх, дохиолол хамгаалалтын төхөөрөмж суурилуулах, галын хор шалгах, заавар зөвлөмжийг байрлуулах.	1000000	I/20, VI/20, IX/20, XI/20				
7	Эдэлбэр газрын үер, газар хөдлөлт, аянга, галын аюулгүй байдлыг хангасан хамгаалалттай, болзошгүй ослын үед ашиглах заавар, схем зургийг нүдэнд харагдахуйц газар ил байрлуулах.	100000	III/01				
8	Байгаль орчныг хамгаалах болон орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээний талаар ажиллагсад, үйлчилгээний ажилтнуудад тодорхой хугацаагаар байгаль орчны сургалт семинар зохион байгуулах.	250000	X/01-ний өдрийн дотор				
9	Нийт ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт улиралд нэг удаа хамрагдах.	-					
10	Анхны тусламж болон яаралтай тусламж үзүүлэх нөхцөлөөр хангагдах.	200000	III/01, VI/01, IX/01, XI/01				
11	Нийт	1600000					

**АРВАН ХОЁР. 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН
БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
---	---	------------------	--------------------	--------------------------------	-----------------------	---	------------------------

**“ЭЛЕКТРОНИКИЙН ХАЯГДАЛ, ХАЯГДАЛ ЗЭС БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР”
ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

1	Нийслэлийн Байгаль орчны газрын БОМТ-ийн биелэлт хариуцсан хэсэгт	Тайлан	2026 оны Биелэлт тайлан	12-р сарын 01-ний дотор		Байгаль орчны газрын мэргэжилтэн, компанийн удирдлагууд	Улаанбаатар хот
2	Байгаль Орчин, Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яам	Тайлан	2027 оны БОМТ	2026.12.31-ний дотор	-	“Нью метод” ХХК-ийн БОМТ-г боловсруулах	Улаанбаатар хот